7.	Газрын тос, хийн чиглэлээр гарсан техникийн аваарь осол болон шүүх, цагдаагийн байгууллагын хүсэлтээр шинжээчээр ажиллах				Баянзүрх дүүргийн 26 дугаар хорооны нутаг дэвсгэрт гарсан осолтой холбогдуулан НХХЯ, ЗТХЯ-тай хамтарсан 2024 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн 06-00/001 дугаартай удирдамжийг дагуу Дащаанжил ХХК-ийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийж 2024 оны 01 сарын 30 өдрийн 13-07/02 дугаартай нэгдсэн танилцуулга гаргаж Улсын онцгой комисс, Монгол Улсын Шадар сайдад тус тус танилцуулав. Мөн Тээврийн цагдаагийн албаны Мөрдөн шалгах хэлтсийн мөрдөгчийн 2024 оны 01 дүгээр сарын 29-ний өдрийн тогтоолын дагуу Баянзүрх дүүргийн 26 дугаар хорооны нутаг дэвсгэрт гарсан осолд шинжээчээр ажиллаж дүгнэлт гаргав.	2024.01.03 2024.06.01	100%
8.	Төлөвлөгөөт бус хяналт шалгалтын удирдамж батлах.				НХШГ-т Дулааны хоёрдугаар цахилгаан станц ТӨХК, Дулааны гуравдугаар цахилгаан станц ТӨХК, Амгалан дулаан станц ТӨХК, Нийслэлийн эрүүл мэндийн газар, "Зорчигч тээвэр тав" ОНӨААТҮГ, Номин газ ХХК, Улаанбаатар хотын Баянгол дүүргийн 31 дүгээр хорооны засаг дарга Г.Ням-Очир, тус дүүргийн иргэн Г.Сүрэнжав, О.Отгон, Б.Амарсанаа, У.Цэрэнжаргал, Хан-Уул дүүргийн иргэн Э.Чинбат, Т.Амартувшин, Г.Гэндэнсүрэн, Сүхбаатар дүүргийн иргэн Ц.Энхтөр, Б.Алтаншагай, Чингэлтэй дүүргийн иргэн Д.Соном, О.Эрдэнэбилэг, Баянзүрх дүүргийн иргэн Х.Болорцэцэг, Сонгинохайрхан дүүргийн иргэн Н.Чинзориг нараас ирүүлсэн өргөдөл, хүсэлтийг үндэслэн төлөвлөгөөт бус шалгалт хийх тухай 06/13/003, 06/13/007, 06/13/004, 06/13/005, 06/13/013, 06/13/014 дугаартай удирдамж боловсруулж батлав.	2024.01.03 2024.06.01	100%
9.	Онцгой нөхцөл байдлтай үед ажиллах				Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдаас өгсөн чиглэлийн дагуу Нийслэлийн хэмжээнд Газрын тосны бутээгдэхүүний бөөний худалдаа, үйлдвэрлэл эрхлэх тусгай зөвшөөрөл эзэмшигч Шунхлай трейдинг ХХК, Содмонгол групп ХХК, Петровис	2024.01.01 2024.02.15	100%

				трейдинг ХХК-ийн газрын тосны бүтээгдэхүүний нэр төрөл, шатахуун хадгалах савнуудын нөөцийн хэмжээнд 2024 оны 01 дүгээр сарын 29, 2 дугаар сарын 20-ны өдрүүдэд хяналт тавьж ажиллалаа.		
10.	Дотоод ажил			Монгол газрын тос боловсруулах үйлдвэр ХХК-ийн орон сууцны барилгын ажлын төсөв, гүйцэтгэлийн явцад гарсан зөрүүтэй асуудлыг няялан шалгах үүрэг бүхий ЗГХЭГ-аас томилсон ажлын хэсэгт ажиллаж дүгнэлт гаргав.	2024.01.03 2024.06.01	100%
				Онцгой байдлын ерөнхий газраас 2024 оны 04 дүгээр сарын 08-ны өдрийн 1/801 дугаартай албан бичгээр ирүүлсэн хүсэлтийн дагуу Кореа газ сэйфти корпорацтай хамтран ажиллах саналыг Газрын тосны бодлогын газартай хамтран боловсруулж хүргүүлэв.	2024.01.03 2024.06.01	100%

ХОЁР.МЭДЛЭГ ЧАДВАРАА ДЭЭШЛҮҮЛЭХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭ

Д/д	Боловсрол, мэргэжил, мэргэшил, ур чадвараа сайжруулах арга хэмжээ	Хүрэх түвшин	Хэрэгжүүлэх ажил	Эхлэх, дуусах огноо
1	2	3	4	5
“ТӨРИЙН АЛБАНЫ ТУХАЙ ХУУЛЬ, САЛБАРЫН ХУУЛЬ, ДАГАЛДАН ГАРСАН ХУУЛЬ ТОГТООМЖИД ЗААСАН МЭДЛЭГ ЧАДВАРЫГ ЭЗЭМШИХ, ТАСРАЛТГҮЙ ХӨГЖҮҮЛЭХ” ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД				
1.1	Мэргэжлийн болон салбарын мэдлэгээ дээшлүүлэх хүрээнд холбогдох сургалт, семинар, хэлэлцүүлэгт хамрагдах	АНУлсын Хөдөлмөрийн Яамны Уул уурхайн аюулгүй байдал, эрүүл ахуйн алба болон Монгол Улсын Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамтай 2024 оны 02 сарын 26-нд байгуулсан санамж бичгийн хүрээнд 2024 оны 5 сард ХНХЯамны дэд сайдаар ахлуулсан албан айлчлалд оролцож, санамж бичгийн хүрээнд цаашид хамтран хийх ажлын талаар хэлэлцээр хийж биелэлтийг хангаж ажиллахаар болсон.	Холбогдох сургалт, семинар, хэлэлцүүлэгт хамрагдана	I-IV улирал
1.2	Салбарын үйл ажиллагаатай холбоотойгоор батлагдан гарсан баримт бичгийг хэрэгжүүлэх, программ төлөвлөлтөд анхаарч ажиллах	2024 оны 05 дугаар сарын 03-ны өдөр Байгаль орчинд ээлтэй хариуцлагатай уул уурхай төслийн нээлтийн үйл ажиллагаа болон тус төслийн хамрах хүрээ холбогдох асуудлуудын талаарх хэлэлцүүлэгт оролцсон.	Холбогдох сургалт, семинар, хэлэлцүүлэгт хамрагдана	I-IV улирал
	Мэргэжлийн болон салбарын мэдлэгээ дээшлүүлэх хүрээнд холбогдох сургалт,	1. ТЗҮГ-аас зохион байгуулсан “Мэдээллийн цаг”-аар дараах мэдээлэлтэй сургалтад хамрагдсан. Үүнд: - Таван толгой ложистик төвийн танилцуулга -		

1.3	семинар, хэлэлцүүлэгт хамрагдах	<p>Болорсофт ХХК-ийн цахим программын тухай - Хаан банкны бүтээгдэхүүний тухай - Удирдлагын академийн багш Алтанцэцэгийн тавьсан "Төрийн албан хаагчийн харилцаа, хандлага сэтгэлгээний өөрчлөлт"-ийн тухай илтгэл</p> <p>2. Цахим хөгжил, харилцаа холбооны яамнаас зохион байгуулсан "Шилэн хяналт цахим системийн тухай" онлайн сургалт</p> <p>3. Нийслэлийн прокурорын газраас зохион байгуулсан "Зөрчлийн хэрэг бүртгэлийн тухай" сургалтад 2024 оны 06 дугаар сарын 07-ны өдөр хамрагдсан.</p> <p>4. Төрийн албаны зөвлөлөөс зохион байгуулдаг 7:4:10 сургалт</p>	
-----	---------------------------------	---	--

Төлөөвлөгөөг үнэлсэн:

Н.Б.Дарга

(албан тушаал)

Тэмдэг

Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн:

Ж.Ч.Ч.Дарга

(албан тушаал)

Тайлагнасан:

С.Х.-ын дарга

(албан тушаал)

Болорсофт ХХК-ийн цахим программын тухай - Хаан банкны бүтээгдэхүүний тухай - Удирдлагын академийн багш Алтанцэцэгийн тавьсан "Төрийн албан хаагчийн харилцаа, хандлага сэтгэлгээний өөрчлөлт"-ийн тухай илтгэл

2. Цахим хөгжил, харилцаа холбооны яамнаас зохион байгуулсан "Шилэн хяналт цахим системийн тухай" онлайн сургалт
3. Нийслэлийн прокурорын газраас зохион байгуулсан "Зөрчлийн хэрэг бүртгэлийн тухай" сургалтад 2024 оны 06 дугаар сарын 07-ны өдөр хамрагдсан.
4. Төрийн албаны зөвлөлөөс зохион байгуулдаг 7:4:10 сургалт



Н.Б.Дарга
(гарын үсэг)

Нэгжийн дарга

А.Д.Давиджонов
(гарын үсэг)

С.Н.Новчендорж

(огноо)

2024. 12. 20.

И.Б.Олонцэх

(огноо)

2024. 12. 09.

Д.Давиджонов

(огноо)

2024. 12. 09.

Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын
2020 оны 100 тоот тушаалын 7 дугаар хавсралт

**СУДАЛГАА, ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ГАЗРЫН
СТАТИСТИК, СУДАЛГААНЫ ХЭЛТСИЙН ДАРГА Б.ДЭЛГЭРЖАРГАЛЫН
/ЦӨМИЙН БОЛОН ЦАЦРАГИЙН ХЯНАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА/
2024 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН**

#	Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж	Төсөв	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин		Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/	Гүйцэтгэл %						
					Эхний хагас	Сүүлийн хагас								
Стратеги төлөвлөгөөний зорилго 1. Салбарын хөрөнгө оруулалтын орчин, шаардлага хэрэгцээг судлах, хөрөнгө оруулалтын орчныг сайжруулах, хөрөнгө оруулалтын хөтөлбөрийг төлөвлөх, судалгаа шинжилгээ хийх, зохицуулах, тайлагнах, гадаад, дотоодын хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний хэрэгжилтийг хангаж, гадаадын шууд хөрөнгө оруулалтын хэмжээг 2022 оны түвшингээс бууруулахгүй байх арга хэмжээ авна.														
Зорилт 1. “Салбарын хөрөнгө оруулалтын орчин, шаардлага хэрэгцээг судлах, хөрөнгө оруулалтын орчныг сайжруулах, хөрөнгө оруулалтын хөтөлбөрийг төлөвлөх, статистик мэдээ, мэдээллийг нэгтгэн боловсруулж, судалгаа шинжилгээ хийх тайлагнах арга хэмжээ авна.”														
1	Арга хэмжээ 1.1. Уул уурхай, хүнд үйлдвэрийн салбараас бүтээгдэхүүн үйлдвэрлэл, борлуулалт, экспорт, импорт, улсын төсвийн төлөвлөгөө, гүйцэтгэл (нийгэм, эдийн засагт үзүүлэх нөлөөлөл) зэрэг мэдээллийг боловсруулж, сар бүр яамны удирдлагыг шуурхай мэдээллээр хангана.	-	Мэдээллийг боловсруулж, танилцуулсан байна.	12 удаа	6 удаа	6 удаа	<p>-Аж үйлдвэрийн салбар (Уул уурхай, олборлох салбар, газрын тосны салбар, хүнд аж үйлдвэрийн салбар)-ын бүтээгдэхүүний нийт үйлдвэрлэл, борлуулалт, хөдөлмөр эрхлэлт, эрдэс бүтээгдэхүүний экспорт, импорт, улсын төсөвт төвлөрүүлсэн татвар, хураамжийн мэдээллийг боловсруулж, удирдлагад танилцуулсан.</p> <p>-Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуулиар Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2024 онд хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн болон тоон хэмжээний үзүүлэлтүүдийн талаарх мэдээллийг уул уурхай, газрын тосны бүтээгдэхүүний экспортын биет хэмжээний талаарх мэдээллийг УУХҮ-ийн сайд, ТНБД-д боловсруулж танилцуулсан.</p> <p>-Эрдэс баялгийн салбарын 1-12 сарын статистик мэдээллийг боловсруулж удирдлагад танилцуулсан.</p> <p>Эхэлсэн, дууссан огноо: 2024.01.02-12.09</p>	100						

2	Арга хэмжээ 1.2. Экспортын голлох ашигт малтмалын зах зээлийн судалгаа хийж, яамны удирдлагыг шуурхай мэдээллээр хангана.	-	Судалгааг боловсруулсан байна.	I-IV улирал	Тухай бүр	Тухай бүр	<p>-Уул уурхайн бүтээгдэхүүний зах зээлийн ханш, үнийн таамаглалыг 2026 он хүртэл гарган 2024.02.20-ны өдөр Сайдад танилцуулсан.</p> <p>-Монголын хөрөнгийн биржээр арилжаалагдаж буй нүүрсний экспортын мэдээллийг боловсруулж удирдлагад танилцуулсан. Мөн Хятадын www.sxcoal.com сайтын зарлаж буй үнийн мэдээллийг Монголын хөрөнгийн биржээр арилжаалагдаж байгаа үнийн мэдээлэлтэй харьцуулсан судалгааг боловсруулж удирдлагад танилцуулсан.</p> <p>-www.sxcoal.com сайтаас Хятадын нүүрс (коксжих, баяжуулсан, эрчим хүч)-ний хэрэглээнд Монгол болон бусад орны нүүрсний эзлэх хувь хэмжээний талаарх мэдээллийг боловсруулж удирдлагад танилцуулсан.</p> <p>-Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуулиар Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2024 онд хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн болон тоон хэмжээний үзүүлэлтүүдийн талаарх мэдээллийг уул уурхай, газрын тосны бүтээгдэхүүний экспортын биет хэмжээний талаарх мэдээллийг гаргаж удирдлагад танилцуулсан.</p> <p>-Bloomberg терминалаас G19 Index-ийн голлох ашигт малтмалын үнийг сар бүр ЭЗХЯ-наас авч боловсруулалт хийн удирдлагыг мэдээллээр хангаж ажилласан.</p> <p>-Эдийн засаг, нийгмийн хөгжлийн үзүүлэлтийн 2023 оны гүйцэтгэл, 2024 оны зорилтод түвшингийн голлох эрдэс түүхий эдийн олборлолт, экспортын мэдээллийг боловсруулсан.</p> <p>Эхэлсэн, дууссан огноо: 2024.01.02-12.09</p>	100
3	Арга хэмжээ 1.3. Алт, зэс, нүүрс, төмөр, газрын тосны бүтээгдэхүүний экспорт хүчин	-	Мэдээллийг боловсруулж танилцуулсан байна.	I-IV улирал	26 удаа	26 удаа	<p>-СЯ, ГЕГ, АМГТГ (ТЗУХ, Нүүрс судалгааны хэлтэс, Геологи, уул уурхайн кадастрын хэлтэс, Газрын тосны ашиглалтын хэлтэс, Газрын тосны бүтээгдэхүүний хэлтэс), Монголбанк Эрүүлмэջ Тавантолгой ХК</p>	100

	төгөлдөр тусгай зөвшөөрөл, эрдэс бүтээгдэхүүний үнийн мэдээллийг 7 хоногоор боловсруулж, яамны удирдлагыг шуурхай мэдээллээр хангана.						Fenwei Energy (www.sxcoal.com) зэрэг байгууллагуудаас 7 хоног тутам голлох ашигт малтмалын олборлолт, экспорт, үнэт металлын худалдан авалт, хайгуул, ашиглалтын тусгай зөвшөөрлийн талаарх мэдээллийг (Уул уурхайн бүтээгдэхүүний экспортын төлөвлөгөө, гүйцэтгэлийн) авч Microsoft Powerpoint (Infographic)-ийн загварын дагуу боловсруулалт хийн олон нийтэд нээлттэй мэдээлж ажилласан. -Лондонгийн металлын бирж (www.lme.com)-д зарлагдаж байгаа эрдэс бүтээгдэхүүний үнэ, БНХАУ-ын нүүрсний үнэ (www.sxcoal.com), Bloomberg терминалаас уул уурхайн голлох ашигт малтмалуудын үнэ, Монголбанкны гадаад валют болон алтны үнэ, бусад эх сурвалжаас үнийн мэдээллийг авч долоо хоног бүр яамны удирдлагад танилцуулсан. Эхэлсэн, дууссан огноо: 2024.01.02-12.09	
4	Арга хэмжээ 1.4. Манай орны ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр, өсөн нэмэгдэх роялтийг хэрхэн ногдуулдаг талаар бусад орны жишээн дээр харьцуулсан судалгаа боловсруулж удирдлагад танилцуулна.	-	Мэдээллийг боловсруулж танилцуулсан байна.	-	1 удаа	26 удаа	-Ашигт малтмалын нөөц ашигласан төлбөрийг бусад улсын жишээн дээр харьцуулсан судалгаа, улсын төсөвт төвлөрүүлсэн орлог, экспорт, хайгуулын ажилд зарцуулсан зардал, хайгуулын ТЗ-ын сонгон шалгаруулалтаас улсын төсөвт төвлөрүүлсэн орлог, АМ-ын ТЗ-ийг шилжүүлэх, эцсийн эзэмшигчийг өөрчлөхтэй холбоотой татвар ногдуулалтын талаарх танилцуулга зэргийг холбогдох газруудаас авч нэгтгэн боловсруулалт хийж удирдлагад танилцуулсан. -Голлох ашигт малтмалын 2020-2023 оны Улсын төсөвт төвлөрүүлсэн АМНАТ болон өсөн нэмэгдэх АМНАТ, эрдэс бүтээгдэхүүний экспорт, ашигт малтмалын дундаж ханшийн талаарх мэдээллийг боловсруулж ҮҮБГ-т хүргүүлсэн Эхэлсэн, дууссан огноо: 2024.01.02-12.09	100
5	Арга хэмжээ 1.5. Салбарын төрийн болон төрийн өмчийн	-	Тайланг нэгтгэж,	2 удаа	1 удаа	1 удаа	Салбарын төрийн өмчийн болон төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгж, улсын чийгжлийн газарнуулын 2024 оны хагас жилийн	50

	оролцоотой компаниудын үйл ажиллагаатай холбоотой үйлдвэрлэлийн болон эдийн засгийн тайлан мэдээг нэгтэн боловсруулж, удирдлагад танилцуулна.		танилцуулсан байна.				жилийн эцсийн үйл ажиллагаатай холбоотой санхүү, эдийн засгийн болон үйлдвэрлэлийн талаарх мэдээллийг нэгтгэн боловсруулсан. Эхэлсэн, дууссан огноо: 2024.01.02-12.09	
6	Арга хэмжээ 1.6. Нөөц нь тогтоогдсон ашигт малтмалын томоохон ордуудыг ашигт малтмал тус бүрээр судлан, эдийн засгийн эргэлтэд оруулах боловсруулж, мэдээлэл танилцуулга, мэдээлэл бэлтгэж удирдлагад танилцуулах.	-	Танилцуулга, мэдээлэл бэлтгэсэн байна.	2 удаа	2 удаа	2 удаа	-Уул уурхайн салбарын хөрөнгө оруулалт шаардлагатай төслийн талаарх мэдээллийг АМГТГ-аас авч нэгтгэн боловсруулалт хийж удирдлагад танилцуулсан. -2020-2024 онд ашиглалтад орсон уул уурхай, хүнд үйлдвэрийн төслүүдийн судалгааг холбогдох газар, хэлтсүүдээс нэгтгэн авч боловсруулалт хийн удирдлагад танилцуулсан. Эхэлсэн, дууссан огноо: 2024.01.02-12.09	100
7	Арга хэмжээ 1.7. МҮ-ын ЗГ-ын 2023 оны 481 дүгээр “2024 оныг Бүсчилсэн хөгжлийг дэмжих жил болгон зарлах тухай” тогтоолын хэрэгжилтийг хангах хурээнд салбарын бүсчлэл болон тухайн бүсэд хэрэгжүүлэх томуохон төсөл, хөтөлбөрүүдийн байршлын саналыг нэгтгэж, талуудын оролцоог хангасан хэлэлцүүлэг зохион байгуулж, үр дүнг ЭЗХЯ-нд хүргүүлнэ.	-	Мэдээлэл боловсруулах , хэлэлцүүлэг зохион байгуулж үр дүнг ЭЗХЯ-нд хүргүүлсэн байх	-	1	1	Монгол Улсын Засгийн газраас 2024 оныг “Бүсчилсэн хөгжлийг дэмжих жил” болгон зарласантай холбогдуулан геологи, уул уурхай, газрын тос, хүнд үйлдвэрийн салбарын төр, хувийн хэвшил, аж ахуйн нэгж, мэргэжлийн холбоод, төрийн болон төрийн бус байгууллагын төлөөллийг оролцуулсан салбар хэлэлцүүлгүүдийг 2024 оны 01 дүгээр сарын 29, 30-ны өдрүүдэд Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам, Үндэсний геологийн албанад зохион байгуулсан. Геологи, уул уурхай, хүнд үйлдвэр, газрын тосны салбарын хэлэлцүүлгээс гарсан саналыг нэгтгэн боловсруулж 2024.02.02-ны өдрийн 03/294 дүгээр албан бичгээр ЭЗХЯ-нд хүргүүлсэн. Түүнчлэн “Бүсчилсэн хөгжлийн зөвлөгөөн”- нд оролцох албан хаагчдын нэрсийг 2024.01.19-ний өдрийн 02/155 дугаар албан бичгээр ЭЗХСайдад, “Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал”-ыг боловсруулсан Ажлын хэсэгт орж ажиллас	100

								албан хаагчдын нэrsийг 2024.01.19-nий өдрийн 03/152 дугаар албан бичгээр ЭЗХЯ-нд, "Бүсчилсэн хөгжлийн урьдчилсан хэлэлцүүлэг"-т оролцох албан хаагчдын нэрс хуваарийг ЭЗХЯ-нд тус тус хүргүүлж ажилласан. Эхэлсэн, дууссан огноо: 2024.01.02-03.29	
8	Арга хэмжээ 1.8. Монгол Улсын хэмжээнд хэрэгжүүлэхээр төлөвлөж буй аж үйлдвэрийн паркууд, стратегийн ордууд болон бүсүүдийн байгаа ашигт малтмалын томоохон ордуудын талаарх мэдээллийг ашигт малтмал тус бүрээр ангилан, боловсруулалт хийж ЭЗХЯ-нд хүргүүлнэ.	-	Мэдээлэл боловсруулж ЭЗХЯ-нд хүргүүлсэн байх	-	1	1	"Бүсчилсэн хөгжлийн дэмжих жил" болгон зарласантай холбогдуулан" Засгийн газрын 2023 оны 481 дүгээр тогтоолыг хэрэгжүүлэх 100 хоногийн ажлын төлөвлөгөөнд тусгасан салбарын хэмжээнд хэрэгжүүлэхээр төлөвлөж буй аж үйлдвэрийн паркууд, стратегийн ордууд болон бүсүүдийн байгаа ашигт малтмалын томоохон ордуудын талаарх мэдээллийг ашигт малтмал тус бүрээр ангилан, боловсруулалт хийж 2024.02.02-ны өдрийн 03/294 дүгээр албан бичгээр ЭЗХЯ-нд хүргүүлсэн. Эхэлсэн, дууссан огноо: 2024.01.02-03.29	100	

СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ЗОРИЛГО 2. "ХУУЛИАР ТУСГАЙЛАН ОЛГОСОН ЧИГҮҮРГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЖ АЖИЛЛАНА." ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД

1	Арга хэмжээ 2.1. Экспортод гаргаж буй ашигт малтмалын бүтээгдэхүүний тухайн сард баримтлах олон улсын зах зээлийн жишиг үнийг баталж, олон нийтэд мэдээлнэ.	-	Жишиг үнийг зарласан байна	12 удаа	6 удаа	6 удаа	-Монгол Улсын Сангийн сайд, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2018.07.27-ны өдрийн 200/A/177 тоот хамтарсан тушаалаар "Экспортод гарч буй уул уурхайн бүтээгдэхүүний ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр тооцох зах зээлийн үнийг нийтэд мэдээлэх" үүрэг бүхий Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг баталсан. Монгол Улсын Ашигт малтмалын тухай хуулийн 47 дугаар зүйл, Монгол Улсын Засгийн газрын 2013 оны 131 дүгээр тогтоол, 2016 оны 81 дүгээр тогтоол, 2019 оны 465 дугаар тогтоолын дагуу Ажлын хэсгийн бүрэлдэхүүн сар бүрийн 10-ны дотор хуралдаж "Экспортод гарч буй уул уурхайн бүтээгдэхүүний ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр тооцох зах зээлийн үнийг нийтэл" мэлзээж ажилласан	100
---	--	---	----------------------------	---------	--------	--------	--	-----

							Эхэлсэн, дууссан огноо: 2024.01.02-12.09	
2	Арга хэмжээ 2.2. УУХҮ-ийн сайд, Төрийн нарийн бичгийн даргын тушаалаар байгуулсан Ажлын хэсгийн үйл ажиллагааг зохион байгуулж, хэрэгжилт, үр дүнг тайлagnана.	-	Гарсан санал, дүгнэлт оновчтой байх	Тухай бүр	Тухай бүр	I-IV улирал	<p>ХБНГУ-ын Засгийн газрын санхүүжилтээр Уул уурхай, хунд үйлдвэрийн яаманд хэрэгжиж буй “Эрдэс баялгийн тогтвортой удирдлагын зөвлөх үйлчилгээ” техникийн хамтын ажиллагааны төслийн хүрээнд “Геологи, уул уурхай, хунд үйлдвэр, газрын тосны салбарын нийгэм эдийн засгийн үнэлгээ”-ний ажлын үйл ажиллагааг удирдан зохион байгуулах, санал дүгнэлт өгөх, ажлын гүйцэтгэлд хяналт тавих, мөн тухайн ажлын техникийн даалгаварыг боловсруулах үүрэг бүхий Ажлын хэсгийг УУХҮЯ-ны Төрийн нарийн бичгийн даргын 2023 оны A/34 дүгээр тушаалаар байгуулсан. Ажлын хэсэг 2024 онд 2 удаа хуралдаж, НЭЗҮ хийх ажлын даалгаварын төслийг боловсруулан ХБНГУ-ын Геошинжлэх ухаан, байгалийн нөөцийн хүрээлэн (БГР)-т хүргүүлсэн. Энэхүү ажлын даалгаварын хүрээнд НЭЗҮ боловсруулах хувь хүн, хуулийн этгээдийг сонгон шалгаруулах ажлыг ХБНГУ-ын Геошинжлэх ухаан, байгалийн нөөцийн хүрээлэн зохион байгуулсан.</p> <p>2024.10.02-ны өдрөөс 05-ны өдрийн хооронд зохион байгуулагдсан “MiningWeek 2024 & MinePro 2024” олон улсын арга хэмжээг зохион байгуулах Ажлын хэсгийг УУХҮЯ-ны ТНБД-ын 2024 оны A/15 дугаар тушаалаар байгуулсан. Арга хэмжээг Уул уурхайн үндэсний ассоциацитай хамтран зохион байгуулах бэлтгэл ажлыг хангахад дэмжлэг үзүүлж ажилласан.</p> <p>Эхэлсэн, дууссан огноо: 2024.01.02-12.09</p>	100
3	Арга хэмжээ 2.3. ХБНГУ-ын “Геошинжлэх ухаан, байгалийн нөөцийн хүрээлэн BGR”-тай хамтран хэрэгжүүлж буй “Эрдэс баялгийн	-	Төслийн төлөвлөгөөг шинэчлэн боловсруулж, хяналт тавьж хамтран	-	1	1	Монгол Улс-Герман Улсын хамтын ажиллагааны хүрээнд “Эрдэс баялгийн тогтвортой удирдлагын зөвлөх үйлчилгээ ТД 2020.2036.0” төсөл 2022 оны 4 дүгээр сараас эхлэн тус яаманд хэрэгжиж байна. Төслийн хүрээнд “Геологи, уул уурхай, хунд үйлдвэр, газрын тосны салбарын	100

тогтвортой удирдлагын зөвлөх үйлчилгээ” /ТД 2020.2036.0/ үзүүлэх төслийн 2023-2025 онд хэрэгжүүлэх төслийн үйл ажиллагаанд хяналт тавьж хамтран ажиллах.	ажилласан байна			<p>нийгэм эдийн засгийн үнэлгээ"-ний ажлын үйл ажиллагааг удирдан зохион байгуулах, санал дүгнэлт өгөх, ажлын гүйцэтгэлд хяналт тавих, мөн тухайн ажлын техникийн даалгаврыг боловсруулах үүрэг бүхий Ажлын хэсгийг УУХҮЯ-ны Төрийн нарийн бичгийн даргын 2023 оны А/34 дүгээр тушаалаар байгуулсан. Ажлын хэсэг 2024 онд 2 удаа хуралдаж, ажлын даалгавар төслийг боловсруулан ХБНГУ-ын Геошинжлэх ухаан, байгалийн нөөцийн хүрээлэн (БГР)-т хүргүүлсэн. Салбарын нийгэм, эдийн засагт үзүүлэх нөлөөллийн үнэлгээний ажлын даалгавар боловсруулах хувь хүн хуулийн этгээдийг сонгон шалгаруулах ажлыг ХБНГУ-ын Геошинжлэх ухаан, байгалийн нөөцийн хүрээлэн зохион байгуулж зарласан. Нэг санал ирсэн боловч холбогдох шаардлагыг хангаагүйн улмаас 2024 оны наймдугаар сард тендер амжилтгүй болж, цаашид үргэлжлүүлэх боломжгүй болсон.</p> <p>“Төслийн үйл ажиллагааны төлөвлөгөөний эцсийн төлөвлөлт ба шинэчлэлтийн хурал”-ыг 2024.10.31-ний өдөр зохион байгуулж үйл ажиллагааны төлөвлөгөөнд өөрчлөлт оруулсан.</p> <p>Мөн төслийн хүрээнд хийгдэх дотоодын зах зээлээс худалдан авах бараа, бүтээгдэхүүнийг НӨАТ-аас чөлөөлөх асуудлыг шийдвэрлэсэн.</p> <p>ХБНГУ-ын Засгийн газрын санхүүжилтээр Уул уурхай, хүнд үйлдвэрийн яаманд хэрэгжиж буй “Эрдэс баялгийн тогтвортой удирдлагын зөвлөх үйлчилгээ” техникийн хамтын ажиллагааны төслийн хүрээнд Англи хэлний ярианы сургалтыг 2024 онд 3 удаа зохион байгуулж, давхардсан тоогоор яамны 62 албан хаагчдыг хамруулсан. Мөн 3Г-ын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлагдсантай холбогдуулан “Мэргэшсэн төслийн удирдагч (Project Management Professional)” бэлтгэх</p>	
--	-----------------	--	--	--	--

							хүсэлтийн BGR-д хүргүүлсэн. Хүсэлтийн дагуу яамны 5 албан хаагчдыг бэлтгэж байгаа бөгөөд холбогдох сургалтыг эхлүүлээд байна. Эхэлсэн, дууссан огноо: 2024.01.02-12.09	
4	Арга хэмжээ 2.4. ЗГХЭГ-ын дэргэдэх Е-Mongolia академийн хөгжүүлэлт хийж буй www.sudalgaag.gov.mn судалгааны нэгдсэн системд УУХҮЯ-ыг төлөөлж модератораар ажиллах.	-	Судалгааг байршуулсан байна	-	6	6	Sudalgaag.gov.mn цахим хуудсанд УУХҮЯ-ны захиалгаар улсын төсвөөр болон гадаад дотоодын төсөл хетөлбөрийн санхүүжилтээр 2020-2024 онд хийгдсэн эрдэм шинжилгээ, судалгааны ажлуудыг байршуулав. Эхэлсэн, дууссан огноо: 2024.01.02-12.09	100
5	Арга хэмжээ 2.5. Монгол Улсын уул уурхайн салбарын нийгэм, эдийн засгийн нөлөөллийн үнэлгээг боловсруулахад бодлогын дэмжлэг үзүүлж, нэгдсэн удирдлагаар хангаж ажиллах.	-	Судалгаа хийж мэдээллээр хангасан байна	-	1 удаа	1 удаа	"Геологи, уул уурхай, хүнд үйлдвэр, газрын тосны салбарын нийгэм эдийн засгийн үнэлгээ"-ний ажлын үйл ажиллагааг удирдан зохион байгуулах, санал дүгнэлт өгөх, ажлын гүйцэтгэлд хяналт тавих, мөн тухайн ажлын техникийн даалгаврыг боловсруулах үүрэг бүхий Ажлын хэсгийг УУХҮЯ-ны Төрийн нарийн бичгийн даргын 2023 оны А/34 дүгээр тушаалаар байгуулсан. Ажлын хэсэг 2024 онд 2 удаа хуралдаж, ажлын даалгавар төслийг боловсруулан ХБНГУ-ын Геошинжлэх ухаан, байгалийн нөөцийн хүрээлэн (БГР)-т хүргүүлсэн. Төслийн хүрээнд салбарын нийгэм, эдийн засагт үзүүлэх нөлөөллийн үнэлгээний ажлын даалгавар боловсруулах хувь хүн хуулийн этгээдийг сонгон шалгаруулах ажлыг ХБНГУ-ын Геошинжлэх ухаан, байгалийн нөөцийн хүрээлэн зохион байгуулсан. Сонгон шалгаруулалтад нэг санал ирсэн боловч холбогдох шаардлагыг хангагүйн улмаас 2024 оны наймдугаар сард тендер амжилтгүй болж, цаашид үргэлжлүүлэх боломжгүй болсон. Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хетөлбөр батлагдсантай холбогдуулан "Мэргэшсэн төслийн үлиялагч /Project Management	100

Professional)" бэлтгэх хүсэлтийг BGR-д хүргүүлж, сонгон шалгаруулалт амжилтгүй болсон Монгол Улсын уул уурхайн салбарын нийгэм, эдийн засгийн нэлөөллийн үнэлгээг боловсруулах ажлын оронд хэрэгжүүлэхээр төслийн үйл ажиллагааны хөтөлбөрт өөрчлөлт оруулсан. Тус сургалтад яамны 5 албан хаагч хамрагдаж байна.

Эхэлсэн, дууссан огноо: 2024.01.02-12.09

СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ЗОРИЛГО 3. ТӨРИЙН ЗАХИРГААНЫ БОЛОН ХҮНИЙ НӨӨЦЛИЙН УДИРДЛАГЫН МАНЛАЙЛЛЫГ ХАНГАЖ, ЭРХ ЗҮЙН ЗӨВЛӨГӨӨ, ДЭМЖЛЭГ ҮЗҮҮЛЭХ, САЛБАРЫН ГАДААД ХАМТЫН АЖИЛЛАГААГ ӨРГӨЖҮҮЛЖ, САНХҮҮ, ЭДИЙН ЗАСАГ, ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫГ ТӨЛӨВЛӨН ЗОХИЦУУЛЖ, ИРГЭД ХУУЛИЙН ЭТГЭЭДЭД ҮЗҮҮЛЖ БАЙГААГ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ДУНДАЖ ХУГАЦАА 2023 ОНД 30 ХОНОГ БАЙГААГ 2024 ОНД 14 ХОНОГ БОЛГОНО.

Зорилт 3. Төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулна.

1	Арга хэмжээ 3.1. Хууль тогтоомж, тогтоол шийдвэр, бодлогын баримт бичиг, байгууллагын үйл ажиллагаа, төсөл, хөтөлбөртэй уялдуулан 2024 оны үйл ажиллагааны болон холбогдох бусад төлөвлөгөөг нэгтгэн боловсруулах, тайлагнах ажлыг зохион байгуулна.	-	Хуулийн хугацаанд шийдвэрлэсэн байх	2	1	1	<p>Салбарын холбогдох хууль тогтоомж, тогтоол шийдвэр, бодлогын баримт бичиг, байгууллагын үйл ажиллагаа, төсөл, хөтөлбөртэй уялдуулан 2024 оны үйл ажиллагааны болон холбогдох бусад төлөвлөгөөг нэгтгэн боловсруулах, тайлагнах ажлыг зохион байгуулсан. Тухайлбал:</p> <ul style="list-style-type: none"> -УУХҮЯ-ны Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн биелэлтийг сар, улирал, хагас жилээр боловсруулж ТЗҮГ-т тухай бүр хүргүүлсэн. -МУ-ын Ерөнхий сайдын шуурхай үүрэг даалгаврын хэрэгжилтийг гаргаж тухай бүр ТЗҮГ-т хүргүүлсэн. -УУХҮЯ-ны сайд, ТНБД-ын тушаалын биелэлтийг гаргаж тухай бүр ТЗҮГ-т хүргүүлсэн. -Газар, хэлстийн хийж гүйцэтгэсэн ажлын тайланг 7 хоног, сараар нэгтгэн боловсруулж тухай бүр ТЗҮГ-т хүргүүлсэн. -Монгол Улсын Засгийн газраас 2024 оныг "Бүсчилсэн хөгжлийг дэмжих жил" болгон зарласантай холбогдуулан ЭЗХЯ-наас боловсруулж ирүүлсэн Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалын төсөл, Монгол Улсын Их хурлын тогтоолын тасал Монгол Улсын Их Хурлын тогтоолын 	100
---	--	---	-------------------------------------	---	---	---	--	-----

							үзэл баримтлал, Засгийн газрын тэмдэглэлийн төсөлд тусгах саналыг газар, хэлтсүүдээс нэгтгэн авч боловсруулан ЭЗХЯ-нд хүргүүлсэн. Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр, хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө, Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөө, хууль тогтоомжийн хэрэгжилт, газар, хэлтсийн болон төрийн жинхэнэ албан хаагчийн 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө, тайланг боловсруулж, тухай бүр тайлагнаж ажилласан. Тухайлбал, Улсын Их Хурлын 2021 оны 106 дугаар тогтоолоор баталсан "Шинэ сэргэлтийн бодлого"-д Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын эрхлэх асуудлын хүрээнд тусгагдсан төслийн хэрэгжилтийг нэгтгэж, холбогдох газарт тайлагнасан. Эхэлсэн, дууссан огноо: 2024.01.02-12.09	
2	Арга хэмжээ 3.2. Иргэн, аж ахуйн нэгж, байгууллагаас ирүүлсэн санал, хүсэлт, өргөдөл, гомдлыг судалж, шийдвэрлүүлэх, хариу хүргүүлэх арга хэмжээ авч, хэрэгжилтийг нэгтгэн холбогдох газарт хүргүүлнэ.	-	Холбогдох хууль тогтоомжид нийцсэн байх	47 хоног	30 хоног	30 хоног	Салбарын үйл ажиллагаатай холбоотой иргэн, аж ахуйн нэгж, байгууллагаас ирүүлсэн санал, хүсэлт, өргөдөл, гомдлыг судалж, шийдвэрлүүлэх, хариу хүргүүлэх арга хэмжээг тухай бүр авч ажилласан. Эхэлсэн, дууссан огноо: 2024.01.02-06.07	100
3	Арга хэмжээ 3.3. УУХҮ-ийн сайдын болон ТНБД-ын шуурхай хуралдаанаас өгсөн чиг үүргийн дагуу холбогдох үйл ажиллагааг зохион байгуулж, хэрэгжилтийг хангаж, тайлагнана.	-	Холбогдох хууль тогтоомжид нийцсэн байх	-	Тухай бүр	Тухай бүр	Төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд салбарын мэргэжлийн холбоод, төрийн бус байгууллагуудын Засгийн газартай хийх санамж бичгийн төслийг боловсруулж, 2024.04.30-ны өдрийн 03/953, 3/954 дүгээр албан бичгээр салбарын мэргэжлийн холбоод, ТББ-д хүргүүлж, удирдлагад танилцуулсан. Стратегийн болон стратегийн ордод хамааруулах боломжтой ордуудын талаар мэдээлэл бэлтгэж удирдлагад 2024.04.20-ны алан танилцуулсан	100

Засгийн газраас 2024 оныг “Бүсчилсэн хөгжлийг дэмжих жил” болгон зарласантай холбогдуулан зохион байгуулсан “Бүсчилсэн хөгжил, орон зайн төлөвлөлтийн өнөөгийн байдал, цаашдын чиг хандлага, тулгамдаж буй асуудлууд” хуралд оролцож, санал солилцсон.

Хууль зүй, дотоод хэргийн яамнаас зохион байгуулсан “Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын тухай” хуулийн төслийн хэлэлцүүлэгт оролцож, 2024.03.25-ны өдөр санал өгсэн.

Канадын хайгуулч, олборлогчдын холбооноос (PDAC-) зохион байгуулах “PDAC-2024” чуулга уулзалтын талаар Батбродерс Майнинг болон Монголиан Коппер компанийн удирдлагатай /төлөөлөлтэй/ уулзаж, зохион байгуулалтын асуудлаар санал солилцсон. Засгийн газрын 2021-2023 онд хэрэгжүүлсэн онцлох ажлуудын товхимолд салбарын талаар тусгах мэдээлэлд яамны газар, хэлтсүүд болон АМГТГ, УГА-наас холбогдох мэдээллийг нэгтгэн боловсруулж, ЗГХЭГ-ын Хэвлэлийн албанд хүргүүлсэн.

Ул уурхай, хүнд үйлдвэрийн салбарын 2023 оны үйл ажиллагааны үр дүн, онцлох ажлуудын талаарх мэдээллийг нэгтгэн боловсруулж, ЗГХЭГ-т /2024.01.05/ хүргүүлсэн.

“Эдийн засгийн форум 2024”-ийн салбар хуралдаан зохион байгуулах УУХҮЯ-ны ТНБД-ын 2024 оны А/44 дүгээр тушаалаар Ажлын хэсгийг байгуулж, хэрэгжилтийг тайлагнан ажилласан.

“MiningWeek 2024 & MinePro 2024”-ийг зохион байгуулах Ажлын хэсгийг УУХҮЯ-ны ТНБД-ын 2024 оны А/15 дугаар тушаалаар байгуулж, хэрэгжилтийг тайлагнан ажилласан.

Эхэлсэн, дууссан огноо: 2024.01.02-12.09

4	Арга хэмжээ 3.4 Бусад яам, газруудаас боловсруулж ирүүлсэн хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн төсөл, бодлогын баримт бичиг, хөтөлбөрийн төсөлд санал өгнө.	-	Холбогдох хууль тогтоомжид нийцсэн байх	-	Тухай бүр	Тухай бүр	<p>Канад Улсын Торонто хотод 2024 оны 3 дугаар сард зохион байгуулсан “Ул уурхайн хайгуул, олборлогчдын чуулга уулзалт (PDAC)”—ын бэлтгэл ажлын зардлыг СЯ-аар батлуулж, арга хэмжээний үеэр хийх мэдээллийг бэлтгэсэн.</p> <p>Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөөний төслийг “Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөө боловсруулах аргачлал”-ын дагуу боловсруулж 2024.01.24-ний өдрийн 01/193 дугаар албан бичгээр ЭЗХЯ-нд хүргүүлсэн.</p> <p>Ашигт малтмалын тухай хуульд 2008-2023 онд оруулсан нэмэлт, өөрчлөлтийн судалгааг гаргаж, хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд санал өгсэн.</p> <p>“Хөрөнгө оруулалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл боловсруулах Ажлын хэсгийн хүрээнд хуулийн төсөлд санал өгсэн.</p> <p>Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг боловсруулж байгаатай холбогдуулан УУХҮ-ийн яамны зүгээс тусгуулах төсөл хөтөлбөрийн саналыг бодлогын газруудаас нэгтгэн авч ЭЗХЯ-нд цахимаар хүргүүлсэн. Мөн тус хөтөлбөр УИХ-ын 27 дугаар тогтоолоор батлагдсантай холбогдуулан хөтөлбөрийн хэрэгжүүлэх төлөвлөгөөнд санал хүргүүлсэн.</p> <p>Эхэлсэн, дууссан огноо: 2024.01.02-12.09</p>	100
5	Арга хэмжээ 3.5 Төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулж батлуулах, хэрэгжилтийг хангах, тайлагнах.	-	Холбогдох хууль тогтоомжид нийцсэн байна	2 удаа	1 удаа	1 удаа	<p>Төрийн жинхэнэ албан хаагчийн 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулж нэгжийн даргаар батлуулан, хэрэгжилтийг ханган, 2024 оны эхний хагас жил, жилийн эцсийн байдлаар тайлагнасан.</p> <p>-АТГ-т жил бүр гаргадаг хөрөнгө, орлогын мэдүүлгийг бөглөж дуусган, баталгаажуулан ТЗУГ-т хүргүүлэв.</p> <p>Эхэлсэн, дууссан огноо: 2024.01.02-12.09</p>	100

#	Үүрэг даалгавар	Өгсөн субъект	Биелэлт
1	2	3	4
НЭГДҮГЭЭР УЛИРЛЫН НЭМЭЛТ АЖЛЫН БИЕЛЭЛТ			
1	“Хойд бүсийн Бүсчилсэн хөгжлийн хэлэлцүүлэг”-т оролцож илтгэл танилцуулах	Байгууллагын удирдлага	<p>ЗГХЭГ-аас 2024.01.19-ний өдөр Удирдлагын академи дээр зохион байгуулсан “Хойд бүсийн Бүсчилсэн хөгжлийн хэлэлцүүлэг”-т оролцож илтгэл танилцуулсан.</p> <p>Эхэлсэн, дууссан огноо: 2024.01.10-01.19 Биелэлтийн хувь: 100%</p>
2	Нарансэвстэй-Мазушань боомтыг нээн ажиллуулах чиглэлээр судалгаа хийж, дүгнэлт, зөвлөмж гаргаж танилцуулах үүрэг бүхий Ажлын хэсгийн бүрэлдэхүүнд орж ажиллах.	Байгууллагын удирдлага	<p>Хилийн Нарансэвстэй-Мазуншань боомтыг нээн ажиллуулах чиглэлээр судалгаа хийж, дүгнэлт, зөвлөмж гаргаж танилцуулсан үүрэг бүхий Ажлын хэсгийн бүрэлдэхүүнд томилогдон ажиллаж салбарын зүгээс шаардлагатай холбогдох мэдээллийг боловсруулан ажлын хэсэгт хүргүүлсэн бөгөөд Хилийн боомтын захиргааны ажлын албаны хурлын танхимд зохион байгуулагдсан Ажлын хэсгийн 2024.01.18-ний өдрийн хуралдаанд оролцож санал өгсөн.</p> <p>Эхэлсэн, дууссан огноо: 2024.01.10-01.18 Биелэлтийн хувь: 100%</p>
3	Салбарын төсөл хөтөлбөр, үндсэн тоон үзүүлэлтүүдийн 2023 оны гүйцэтгэл, 2024 оны төлөвлөгөөг холбогдох газар, хэлтсээс авч нэгтгэн Монголбанкинд хүргүүлэх.	Байгууллагын удирдлага	<p>Монгол Улсын богино, дунд хугацааны хандлагыг судалж, бодлогын шийдвэр гаргахад шаардлагатай салбарын төсөл хөтөлбөр, үндсэн тоон үзүүлэлтүүдийн 2023 оны гүйцэтгэл, 2024 оны төлөвлөгөөг холбогдох газар, хэлтсээс авч нэгтгэн Монголбанкинд цахимаар хүргүүлэв.</p> <p>Эхэлсэн, дууссан огноо: 2024.01.18-01.26 Биелэлтийн хувь: 100%</p>
4	УУХҮЯ-ын ТНБД-ын Аймгуудын Засаг дарга нартай хийх уулзалтын үеэр тавих илтгэлийг бэлтгэж удирдлагад танилцуулах.	Байгууллагын удирдлага	<p>УУХҮЯ-ын ТНБД-ын Аймгуудын Засаг дарга нартай хийх уулзалтын үеэр тавих илтгэлийг бэлтгэж удирдлагад танилцуулсан.</p> <p>Эхэлсэн, дууссан огноо: 2024.01.10-01.28 Биелэлтийн хувь: 100%</p>
5	Статистикийн программууд дээр өгөгдөл цуглуулах, дүн шинжилгээ хийх арга аргачлал, нийгэм эдийн засгийн мэдээ тайлан боловсруулах сургалтыг зохион байгуулах.	Байгууллагын удирдлага	<p>Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам, ХБНГУ-ын Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн яам болон “Геошинжлэх ухаан, байгалийн нөөцийн хүрээлэн (BGR)”-тэй хамтран хэрэгжүүлж буй “Эрдэс баялгийн тогтвортой удирдлагын зөвлөх үйлчилгээ” (ТД 2020.2036.0) техникийн хамтын ажиллагааны төслийн хүрээнд 2024 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан статистикийн программууд дээр өгөгдөл цуглуулах, дүн шинжилгээ хийх арга аргачлал, нийгэм эдийн засгийн мэдээ тайлан боловсруулах сургалтыг зохион байгуулах тухай албан бичгийг боловсруулж ҮСХ-нд хүргүүлсэн. Үүнтэй холбогдуулан яамны болон харьяа төрийн захиргааны байгууллагын алба хаагчдыг статистикийн сургалтад хамруулахаар тохиролцов.</p>

			Биелэлтийн хувь: 100%
6	Засгийн газрын 2022 оны 340 дүгээр тогтоолын хэрэгжилтийг хангах хүрээнд батлагдсан “2023 онд салбарын яам, агентлаг, харьяа байгууллагын эрхлэх асуудлын хүрээний зарим чиг үүргийг хувийн хэвшил, төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэх төлөвлөгөө”-ний биелэлтийг мөн 2024 онд гүйцэтгүүлэх ажил, үйлчилгээний төлөвлөгөөний саналын хамт ЗГХЭГ-т хүргүүлэх.	Байгууллагын удирдлага	<p>Засгийн газрын 2022 оны 340 дүгээр тогтоолын хэрэгжилтийг хангах хүрээнд батлагдсан “2023 онд салбарын яам, агентлаг, харьяа байгууллагын эрхлэх асуудлын хүрээний зарим чиг үүргийг хувийн хэвшил, төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэх төлөвлөгөө”-ний биелэлтийг мөн 2024 онд гүйцэтгүүлэх ажил, үйлчилгээний төлөвлөгөөний саналын хамт ЗГХЭГ-т хүргүүлсэн.</p> <p>Эхэлсэн, дууссан огноо: 2024.01.02-01.16</p> <p>Биелэлтийн хувь: 100%</p>
7	Төрийн бүтээмжийн үндэсний хороо, Үндэсний статистикийн хороо, Цахим хөгжил, харилцаа холбооны яам хамтран “Төрийн байгууллагуудын мета өгөгдлийн цахим платформ” байгуулахаар ажиллаж байгаатай холбогдуулан АМГТГ, УГА-ын цахим санд хуримтлуулж буй өгөгдлийн талаарх мэдээллийг Үндэсний статистикийн хорооноос боловсруулсан цахим асуулгын дагуу бөглүүлсэн.	Байгууллагын удирдлага	<p>Төрийн бүтээмжийн үндэсний хороо, Үндэсний статистикийн хороо, Цахим хөгжил, харилцаа холбооны яам хамтран “Төрийн байгууллагуудын мета өгөгдлийн цахим платформ” байгуулахаар ажиллаж байгаатай холбогдуулан АМГТГ, УГА-ын цахим санд хуримтлуулж буй өгөгдлийн талаарх мэдээллийг Үндэсний статистикийн хорооноос боловсруулсан цахим асуулгын дагуу бөглүүлсэн.</p> <p>Эхэлсэн, дууссан огноо: 2024.01.02-03.20</p> <p>Биелэлтийн хувь: 100%</p>
8	Улсын Их Хурлын 2024 оны хаврын ээлжит чуулганы нэгдсэн хуралдаанд хийх Монгол Улсын Ерөнхий сайдын мэдээллийн сэдэвт мэдээлэл бэлтгэх.	Байгууллагын удирдлага	<p>Улсын Их Хурлын 2024 оны хаврын ээлжит чуулганы нэгдсэн хуралдаанд хийх Монгол Улсын Ерөнхий сайдын мэдээллийн сэдэвт Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын эрхлэх асуудлын хүрээнд тусгах саналыг холбогдох газруудаас авч нэгтгэн ЗГХЭГ-т хүргүүлсэн.</p> <p>Эхэлсэн, дууссан огноо: 2024.02.01-02.26</p> <p>Биелэлтийн хувь: 100%</p>
9	Улсын Их Хурлын 2024 оны ээлжит сонгуулийг 2024 оны 06 дугаар сарын 28-ны өдөр санал авах өдрөөр товлон зарласантай холбогдуулан салбарт ажиллаж буй мэргэжилтэй ажиллах хүчний судалгааг боловсруулж СЕХ-нд хүргүүлэх.	Байгууллагын удирдлага	<p>Улсын Их Хурлын 2024 оны ээлжит сонгуулийг 2024 оны 06 дугаар сарын 28-ны өдөр санал авах өдрөөр товлон зарласантай холбогдуулан салбарт ажиллаж буй мэргэжилтэй ажиллах хүчний судалгааг холбогдох газруудаас авч нэгтгэн СЕХ-нд хүргүүлсэн.</p> <p>Эхэлсэн, дууссан огноо: 2024.02.01-02.29</p> <p>Биелэлтийн хувь: 100%</p>
10	УУХҮЯ-ны ТНБД-ын удирдамжийн дагуу 2024.01.29-ний өдрөөс 2024.02.09-ний өдрийн хооронд Шатахууны үйл ажиллагаа	Байгууллагын удирдлага	<p>УУХҮЯ-ны ТНБД-ын удирдамжийн дагуу 2024.01.29-ний өдрөөс 2024.02.09-ний өдрийн хооронд Шунхтай ХХК-ийн УБ дахь агуулах болон ШТС-дэд хяналт тавьж, өдөр бүр шатахууны үлдэгдлийн мэдээг нэгтгэн боловсруулж УУХҮ-ийн сайдад танилцуулсан.</p> <p>Эхэлсэн, дууссан огноо: 2024.01.29-02.09</p>

	Эрхэлдэг аж ахуйн нэгжүүдэд ажиллах.		Биелэлтийн хувь: 100%
11	2024 оны 03 дугаар сарын 27-28-ны өдрүүдэд Дархан-Уул, Сэлэнгэ аймгуудад албан томилотоор ажиллаж Дарханы төмөрлөгийн үйлдвэр, “Цемент шохой” ХХК-ийн үйл ажиллагаатай танилцаж, компанийн удирдлага болон ажилтан, алба хаагчидтай уулзалт зохион байгуулах.	Байгууллагын удирдлага	<p>Үйлдвэржилтийн бодлогын байнгын хорооны дарга Г.Ганболд, Улсын Их Хурлын гишүүн, Үйлдвэржилтийн бодлогын байнгын хорооны гишүүн Ж.Эрдэнэбат болон Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны Хүнд үйлдвэрийн бодлогын газрын дарга С.Сүхбат, Судалгаа, хөрөнгө оруулалтын газрын Статистик судалгааны хэлтсийн дарга Б.Дэлгэржаргал, ахлах мэргэжилтэн Ц.Тэмүүжин нар 2024 оны 03 дугаар сарын 27-28-ны өдрүүдэд Дархан-Уул, Сэлэнгэ аймгуудад албан томилотоор ажиллан Дарханы төмөрлөгийн үйлдвэр, “Цемент шохой” ХХК-ийн үйл ажиллагаатай танилцаж, компанийн удирдлага болон ажилтан, алба хаагчидтай уулзалт хийж хувийн хэвшлийн аж ахуйн нэгжийн менежментээр ажиллаж байгаад төрийн өмчлөлд буцааж авсан компаниудад шаардлагатай хууль, эрх зүйн дэмжлэг үзүүлэх талаар санал солилцсон.</p> <p>Эхэлсэн, дууссан огноо: 2024.03.27.-03.28</p> <p>Биелэлтийн хувь: 100%</p>
12	PDAC2024 Олон улсын эрдэс баялгийн хайгуул, олборлолтын чуулга уулзалтын үеэр тараагдах Урилга, Ашигт малтмалын тухай хуулийн шинэчилсэн найруулгын товхимол, Эрдэс баялгийн салбарын товч мэдээллийг хэвлүүлэх.	Байгууллагын удирдлага	<p>Канад улсын Торонто хотод 2024 оны 3 дугаар сарын 3-6-ны өдрүүдэд зохион байгуулагдах PDAC2024 Олон улсын эрдэс баялгийн хайгуул, олборлолтын чуулга уулзалтын үеэр тараагдах Урилга, Ашигт малтмалын тухай хуулийн шинэчилсэн найруулгын товхимол, Эрдэс баялгийн салбарын товч мэдээллийг хэвлүүлэх санхүүжилтийг тус яаманд хэрэгжиж буй Германы “Эрдэс баялгийн удирдлагын зөвлөх үйлчилгээ” төслийн санхүүжилтээр хэвлүүлсэн.</p> <p>Эхэлсэн, дууссан огноо: 2024.01.02.-01.30</p> <p>Биелэлтийн хувь: 100%</p>
13	ХБНГУ-ын Засгийн газрын санхүүжилтээр Уул уурхай, хүнд үйлдвэрийн яаманд хэрэгжиж буй “Эрдэс баялгийн тогтвортой удирдлагын зөвлөх үйлчилгээ” техникийн хамтын ажиллагааны төсөл	Байгууллагын удирдлага	<p>Монгол Улс-Герман Улсын хамтын ажиллагааны хүрээнд “Эрдэс баялгийн тогтвортой удирдлагын зөвлөх үйлчилгээ ТД 2020.2036.0” төсөл 2022 оны 4 дүгээр сараас эхлэн тус яаманд хэрэгжиж байна.</p> <p>Төслийн хүрээнд “Геологи, уул уурхай, хүнд үйлдвэр, газрын тосны салбарын нийгэм эдийн засгийн үнэлгээ”-ний ажлын үйл ажиллагааг удирдан зохион байгуулах, санал дүгнэлт өгөх, ажлын гүйцэтгэлд хяналт тавих, мөн тухайн ажлын техникийн даалгаврыг боловсруулах үүрэг бүхий Ажлын хэсгийг УУХҮЯ-ны Төрийн нарийн бичгийн даргын 2023 оны А/34 дүгээр тушаалаар байгуулсан. Ажлын хэсэг 2024 онд 2 удаа хуралдаж, ажлын даалгавар төслийг боловсруулан ХБНГУ-ын Геошинжлэх ухаан, байгалийн нөөцийн хүрээлэн (БГР)-т хүргүүлсэн.</p> <p>Төслийн хүрээнд салбарын нийгэм, эдийн засагт үзүүлэх нөлөөллийн үнэлгээний ажлын даалгавар боловсруулах хувь хүн хуулийн этгээдийг сонгон шалгаруулах ажлыг ХБНГУ-ын Геошинжлэх ухаан, байгалийн нөөцийн хүрээлэн зохион байгуулахаар бэлтгэл ажлыг хангаж байна.</p> <p>Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам, ХБНГУ-ын Геошинжлэх ухаан, байгалийн нөөцийн хүрээлэн (БГР)-тай хэмтран үзнэгжлиүүж буй</p>

			<p>“Эрдэс баялгийн тогтвортой удирдлагын зөвлөх үйлчилгээ” (ТД 2020.2036.0) төслийн хүрээнд хийгдэх дотоодын зах зээлээс худалдан авах бараа, бүтээгдэхүүнийг НӨАТ-аас чөлөөлөх асуудлыг шийдвэрлэсэн.</p> <p>ХБНГУ-ын Засгийн газрын санхүүжилтээр Уул уурхай, хүнд үйлдвэрийн яаманд хэрэгжиж буй “Эрдэс баялгийн тогтвортой удирдлагын зөвлөх үйлчилгээ” техникийн хамтын ажиллагааны төслийн хүрээнд Англи хэлний ярианы сургалтыг 2024.04.17-2024.05.17-ны өдрүүдэд зохион байгуулж яамны 24 албан хаагчдыг хамруулсан.</p> <p>Төслийн удирдагч шинээр томилогдон ирсэн холбогдуулан түүний виз, оршин суух зөвшөөрлийн хүсэлтийг Гадаадын иргэн харьяатын газарт уламжлан шийдвэрлүүлсэн.</p> <p>Эхэлсэн, дууссан огноо: 2024.01.02.-06.07 Биелэлтийн хувь: 100%</p>
14	Монголын үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилгын Ажлын албан үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх, хэрэгжилтийг хангах	Олборлох Байгууллагын удирдлага	<p>Нэгтгэл тайлан боловсруулах ажлын хүрээнд Монголын ОҮИТБС-ын 2023 оны буюу 18 дугаар тайланг боловсруулах ажлын даалгаврыг боловсруулж, сонгон шалгаруулалтыг 2024.04.04-ний өдөр зарласан. Сонгон шалгаруулалтаар СИКА ХХК, Гроут Файненс аудит ХХК-ийн түншлэл шалгарч, 2024.05.10-ны өдөр гэрээ байгуулсан. Гэрээний дагуу тайлан боловсруулах ажлыг эхлээд байна.</p> <p>Эрдэс баялгийн салбарын ил тод байдлын хууль, эрх зүйн орчныг бүрдүүлэх хүрээнд Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын хуулийн төслийг Хууль зүй, дотоод хэргийн яам хариуцаж байгаа бөгөөд ОҮИТБС-ын Ажлын албанаас төслийг хэлэлцүүлэх ажлыг идэвхжүүлэх, олон нийтэд ойлгуулах хүрээнд 2024 оны 2-р сард хуулийн төслийг Төрийн байгууллага, Иргэний нийгмийн байгууллагуудаар хэлэлцүүлж, санал авсан. Хуулийн төслийг 2024 онд батлагдана гэсэн хүлээлттэй байна.</p> <p>Мэдээлэл түгээх ажлыг сайжруулах боломжийг судлах, олборлох салбарын үйл ажиллагаанд олон нийтийн хяналт тавих үйл ажиллагааг хэрэгжүүлэх хүрээнд шинэ системээр тайлан гаргах аргачлал, зааварчилгааны талаарх сургалтыг ОҮИТБС-ын дэд зөвлөлүүдэд 2024.03.26-ны өдөр болон 2024.04.24-ний өдрүүдэд цахимаар зохион байгуулж, 21 аймаг, сум дүүргийн 33 төлөөллийг оролцуулсан. Компаниудад шинэ системээр тайлан гаргах сургалтыг Дазо ХХК-тай хамтран зохион байгуулж, 202 компанийн төлөөллийг оролцуулсан. ОҮИТБС-ын Олон улсын нарийн бичгийн газартай хамтран Баталгаажуулалтын семинарыг Үндэсний зөвлөл, Ажлын хэсгийн гишүүдийн хүрээнд 2024.06.03, 04-ний өдрүүдэд зохион байгуулж, үйл ажиллагааны төлөвлөгөөг 2023 оны шинэ стандартын шаардлагад нийцүүлэн шинэчилсэн.</p>

			<p>ОУИТБС-ын Олон улсын нарийн бичгийн газартай хамтран Төв Ази, Кавказын орнуудын туршлага солилцох семинарыг 2024.06.05-2024.06.07-ны өдрүүдэд Улаанбаатар хотноо анх удаа зохион байгуулсан. Энэ арга хэмжээнд Монгол, Армен, Казакстан, Кыргызстан улсуудын төлөөлөл оролцож, гэрээ, эцсийн өмчлөгч, мэдээлэл өгөгдлийн ил тод байдлын талаар туршлага солилцож, цаашид хамтран ажиллахаар тохирсон.</p> <p>Эхэлсэн, дууссан огноо: 2024.01.02.-06.07 Биелэлтийн хувь: 100%</p>
--	--	--	---

ХОЁРДУГААР УЛИРЛЫН НЭМЭЛТ АЖЛЫН БИЕЛЭЛТ

	Монголын уул уурхайн 7 хоног (Mongolian Mining week-2023) олон улсын арга хэмжээний үеэр тараах салбарын мэдээллийн товхимол хэвлүүлэх.	Байгууллагын удирдлага	<p>Монголын уул уурхайн 7 хоног (Mongolian Mining week-2023) олон улсын арга хэмжээний үеэр тараах салбарын мэдээллийн товхимлыг /guideline/ санхүүжүүлэх хүсэлтийг Германы BGR төслийн удирдагчид санал тавьсны дагуу 3000 ширхэг товхимол хэвлэх санхүүжилтийг шийдвэрлэсэн.</p> <p>Эхэлсэн, дууссан огноо: 2024.03.01-03.30 Биелэлтийн хувь: 100%</p>
13	Улаанбаатар хотноо 2024 оны 10 дугаар сарын 07-ноос 10-ны өдрийн хооронд зохион байгуулагдах "Уул уурхайн 7 хоног-2024" эрдэс баялгийн салбарын чуулга уулзалтыг зохион байгуулахад шаардлагатай бэлтгэл ажлыг хангах үүрэг бүхий Ажлын хэсгийг байгуулах.	Байгууллагын удирдлага	<p>Улаанбаатар хотноо 2024 оны 10 дугаар сарын 07-ноос 10-ны өдрийн хооронд зохион байгуулагдах "Уул уурхайн 7 хоног-2024" эрдэс баялгийн салбарын чуулга уулзалтыг зохион байгуулахад шаардлагатай бэлтгэл ажлыг хангах үүрэг бүхий Ажлын хэсгийг ТНБД-ын тушаалаар байгуулав.</p> <p>Эхэлсэн, дууссан огноо: 2024.04.30 Биелэлтийн хувь: 100%</p>
14	Салбарын мэргэжлийн холбоодтой хамтын ажиллагааны санамж бичиг байгуулах.	Байгууллагын удирдлага	<p>Газрын тосны салбарын төрийн бус байгуулагуудын оролцоог хангах, тухайн салбарын хөрөнгө оруулалтыг дэмжих зорилгоор хамтын ажиллагааны Санамж бичиг байгуулах тухай албан бичгийг боловсруулж 05 дугаар сарын 07-ний өдөр нийт 7 ТББ-д хүргүүлсэн.</p> <p>Эхэлсэн, дууссан огноо: 2024.05.01-06.10 Биелэлтийн хувь: 100%</p>

ГУРАВДУГААР УЛИРЛЫН НЭМЭЛТ АЖЛЫН БИЕЛЭЛТ

	"Хариуцлагатай Уул Уурхай" Хойд бүсийн чуулга уулзалтад оролцох.	Байгууллагын удирдлага	<p>Монголын Уул Уурхайн Үндэсний Ассоциациас уламжлал болгон зохион байгуулдаг "Хариуцлагатай Уул Уурхай" бүсийн чуулга уулзалт Хойд бус буюу Хөвсгөл аймгийн Мөрөн хотод ирэх сарын 12, 13-нд зохион байгуулагдсан. Энэхүү чуулга, уулзалтын зорилго нь эрдэс баялгийн салбарын ашиг тус, үр нөлөөлөл, ил тод байдлыг оролцогч талуудад зөвөөр хүргэх, хариуцлагатайгаар үйл ажиллагаа явуулж буй уул уурхайн төслийдийг олон нийтэд таниулах замаар оролцогч талуудын хамтын ажиллагааг сайжруулахад оршино.</p>
--	--	------------------------	--

			<p>Чуулга, уулзалтад Хойд бүсэд хамаарагдах Орхон, Булган, Хөвсгөл аймгуудад хайгуул олборлолтын үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж болон тухайн бүсийн төрийн байгууллага, иргэний нийгмийн байгууллагын төлөөллүүд, орон нутгийн иргэдийн төлөөлөл оролцсон. Хойд бүсийн "Хариуцлагатай уул уурхай" өдөрлөгийг Аж үйлдвэр, эрдэс баялгийн яам, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам, Ашигт малтмал, газрын тосны газар, Монголын Уул уурхайн үндэсний ассоциаци хамтран зохион байгуулж, арга хэмжээг санхүүжүүлэгч, дэмжигч байгууллагаар Платинум Ланд ХХК, Хургатай хайрхан, Байгаль орчинд ээлтэй хариуцлагатай уул уурхай төсөл ажилласан. Эхэлсэн, дууссан огноо: 2024.09.12-13 Биелэлтийн хувь: 100%</p>
--	--	--	---

ДӨРӨВДҮГЭЭР УЛИРЛЫН НЭМЭЛТ АЖЛЫН БИЕЛЭЛТ


21	"Хариуцлагатай Уул Уурхай" Говийн бүсийн чуулга уулзалтад оролцох	Байгууллагын удирдлага	<p>"Хариуцлагатай Уул Уурхай" Говийн бүсийн чуулга уулзалтыг Өмнөговь аймгийн ЗДТГ, Цогтцэций ЗДТГ, АМГТГ-ийн Говийн бүсийн төлөөлөгчийн газартай хамтран Өмнөговь аймгийн Цогтцэций сумд зохион байгуулгадлаа. Уг арга хэмжээнд Говийн бүсэд хамаарагдах Өмнөговь, Дундговь, Дорнговь, Говьсүмбэр аймгуудад хайгуул олборлолтын үйл ажиллагаа явуулж буй ААН болон тухайн бүсийн төрийн байгууллага, иргэний нийгмийн байгууллагын төлөөллүүд, орон нутгийн иргэдийн төлөөлөл нийлсэн 350 гаруй хүн оролцсон бөгөөд уг бүсэд үйл ажиллагаа явуулж буй жижиг дунд үйлдвэрлэлийн 20-н ААН үзэсгэлэн гаргаж, 15-н уул уурхайн төслийд "Нээлттэй ажлын байрны өдөрлөг"-ийг чуулганд оролцогч болон иргэдэд танилцууллаа. Мөн арга хэмжээний 2 дахь өдөр оролцогчид Өмнөговь аймгийн Цогтцэций сумд байрлах МУУҮА-ийн Зөвлөлийн гишүүн Энержи Ресурс ХХК-аар зочилсон. Уг арга хэмжээнд Дундговь, Дорнговь, Говьсүмбэр аймгуудын төрийн байгууллагын төлөөлөл, иргэний нийгмийн байгууллагын төлөөлөл, орон нутгийн иргэдийн төлөөлөл болон ААН-үүдийн төлөөлөл нийлсэн 60 гаруй хүн оролцож уурхайн үйл ажиллагаа, усан сан, ус цэвэршүүлэх байгууламж, цахилгаан станц, Цэций хороолол, Мөрөөдөл сургууль, цэцэрлэг, баяжуулах үйлдвэртэй танилцсан юм. Эхэлсэн, дууссан огноо: 2024.11.16-17 Биелэлтийн хувь: 100%</p>
22	Монголын ОҮИТБС-ын Үндэсний зөвлөлийн 22-р хуралдааныг зохион байгуулах.	Байгууллагын удирдлага	<p>Монголын ОҮИТБС-ын Үндэсний зөвлөлийн 22-р хуралдааныг 2024.11.29-ний өдөр Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны хурлын танхимд зохион байгуулсан. Хуралдаанаар Монголын ОҮИТБС-ын 2023 оны буюу 18 дугаар нэгтгэл тайланг танилцуулж, 2024 оны ажлын төлөвлөгөөний биелэлт, 2025 оны ажлын төлөвлөгөөний төслийг хэлэлцэн. Эхэлсэн, дууссан огноо: 2024.11.29 Биелэлтийн хувь: 100%</p>

ГУРАВ. МЭДЛЭГ ЧАДВАРАА ДЭЭШЛҮҮЛЭХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭ

#	Боловсрол, мэргэжил, мэргэшил, ур чадвар	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин	Эхлэх, дуусах огноо
1	2	3	4	
3.1	Хариуцсан ажил, албан тушаалын зорилго, зорилт, чиг үүргийг хэрэгжүүлэхэд чиглэсэн сургалт, хурал, зөвлөгөөнд оролцно.	Сургалтад хамрагдсан байна	Төрийн албаны зөвлөлөөс зохион байгуулсан "7:4:10" сургалт /7хоног бүр-/д хамрагдсан. "Төрийн албан хаагчдыг ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх" хөтөлбөрт хамрагдсан. ОҮИТБС ба Монгол Улс дахь ОҮИТБС-ын Олон талын оролцоот Ажлын хэсэгтэй хамтарсан Баталгаажуулалтын семинарт оролцсон. Төв Ази ба Кавказын бус нутгийн ОҮИТБС-ын гишүүн орнуудын туршлага солилцох, харилцан суралцах уулзалт, арга хэмжээнд оролцсон. Гамшгийн аюулын зарлан мэдээллийн сургалт, дадлага хийхтэй холбоотойгоор Онцгой байдлын ерөнхий газраас зохион байгуулсан сургалтад хамрагдсан. Биелэлтийн хувь: 100	2024.01.02-12.09

Тайланг үнэлсэн:

Төрийн нарийн бичгийн дарга
(албан тушаал)
Тэмдэг



Судалгаа, хөрөнгө оруулалтын газрын дарга
/Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга/
(албан тушаал)
Тэмдэг

Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн:
Хяналт шинжилгээ үнэлгээ,
дотоод аудитын газрын дарга
(албан тушаал)

Нэгжийн дарга
(огноо) 2024.12.09

Тайлагнасан:
Судалгаа, хөрөнгө оруулалтын газрын
Статистик, судалгааны хэлтсийн дарга
/Цөмийн болон цацрагийн хяналтын хэлтсийн дарга/
(албан тушаал)

Нэгжийн дарга
/Б.ДЭЛГЭРЖАРГАЛ/
(огноо) 2024.12.09

Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын
даргын 2023 оны 98 дугаар тушаалын
6 дугаар хавсралт

УУЛ УУРХАЙ, ХҮНД ҮЙЛДВЭРИЙН ЯАМНЫ САЛБАРЫН ХЯНАЛТЫН ГАЗРЫН
АХЛАХ ШИНЖЭЭЧ А.БЯМБАДОРЖИЙН 2024 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

Нэг. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлт ийн хувь
1	2	3	4	5	6	7	

